



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№118 /332/

2022.07.01

Цаг үе, үйл явдал

## ХУРДАН МОРИНЫ САЛБАР ХОРОО ХУРАЛДЛАА

Тулгар Төрийн 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 816, Ардын Хувьсгалын 100, 101 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Хурдан морины салбар хороо өчигдөр хуралдаж дараах асуудлын хүрээнд хэлэлцлээ. Хурлын эхэнд Хурдан морины салбар хорооны гишүүдийг танилцуулсны дараа тус салбар хорооны нарийн бичгийн дарга хурандаа Г.Ялалт Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны Бүртгэлийн дэд хороо, хэмжилт хийх ажлын хэсэг, Зохион байгуулах ажлын хэсэг, Даамал, дэд даамал томилох тогтоолыг танилцуулсан юм.

Харин хурлын төгсгөлд тус салбар хорооны орлогч дарга бригадын генерал Ж.Болдбаатар гишүүдийн ажил, үүргийн хуваарийг танилцуулсан юм. Мөн тус салбар хорооны дарга бригадын генерал Д.Ганхуяг нийт бие бүрэлдэхүүнд хандан үүрэг, чиглэл өгч ажиллалаа.

Энэ үеэр бригадын генерал Д.Ганхуяг "Цар тахлын нөхцөл

байдлаас шалтгаалж өмнө жилийн Үндэсний их баяр наадмыг тэмдэглээгүй өнжсөнтэй холбоотойгоор энэ жил нөхөж тэмдэглэх болсон. Хурдан морины салбар хорооны гишүүд Та бид төр засгаас оногдуулсан энэ ажлыг алдаа мадаггүйгээр зохион байгуулах үүргийг хүлээсэн, хамтдаа ард нь гарна гэдэгт итгэлтэй байна. Бид батлагдсан хууль, дүрмийн хэмжээнд энэхүү ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Тиймээс хүн болгоноос хичээл, зүтгэл шаардагдана. 7 дугаар сарын 1-ээс хугацаат цэргийн алба хаагчид Хүй долоон худагт байрлах бол 7 дугаар сарын 2-нд нь бид бүхэн төхөөрөмжөө очиж шалгана. Зөрчил маргаангүйгээр явуулахын тулд дэлгэцүүдийг байрлуулан, болж буй үйл явцыг бодитоор нь харуулна. Хэрвээ ямар нэгэн асуудал гарвал бичлэгээ шүүж үзэх боломжтой" гэдгийг хэлээд нийт бие бүрэлдэхүүнд ажлын амжилтыг хүсэн ерөөлөө.



## МОНГОЛ ЦЭРЭГ ГЕННИСИЙН АМЖИЛТЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООЛОО



Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн алба хаагч, цэрэгжлийн спортын мастер ахлагч С.Батцэнгэл өнгөрсөн 3 дугаар сарын 18-ны өдөр буюу "Монгол цэргийн өдөр"-өөр мөрдэс нэгт нөхдөдөө бэлэг барьж, 1101 сонс эргэж байсан бол өнөөдөр 1111 эргэж, геннисийн амжилтыг шинэчлэн тогтоож чадлаа.

Түүнээс баярын сэтгэгдлийг нь хуваалцахад "Намайг энэ хүртэл дэмжсэн багш, дасгалжуулагч, анги хамт олон, гэр бүл, мөрдэс нэгт нөхдөдөө маш их баярлалаа. Анх 2020 оны Зэвсэгт хүчний цэрэгжлийн спортын аварга шалгаруулах тэмцээний сонс эргэлтийн төрөлд түрүүлчээд "Би яагаад энэ амжилтаа дэлхийнх болгож болохгүй гэж" бодсон. 2016, 2018, 2019 онуудад ч гэсэн энэ төрөлдөө түрүүлж, хошой аварга болсон байсан учраас чадна гэдэгтээ ч итгэсэн. Зорилгоо биелүүлэхийн төлөө хичээсэн маань өнөөдөр бодит биеллээ олсонд баяртай байна. Үндсэндээ 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс бэлтгэлдээ гарсан. ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийнхны гаргасан төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн Сургалтын төвийн дарга, хошууч Н.Ганзориг багшийн удирдлага дор бэлтгэлээ чамбайрууллаа. Өнөөдрийн амжилттай маань салшгүй холбоотой Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ багштай хамт олондоо маш их баярлалаа" гэсэн юм.

Тэрээр сонс эргэлтээс гадна холын зайн марафоноор хичээллэдэг, энэ төрөлдөө хэд хэдэн амжилтыг шинэчлэн тогтоож байсан тамирчин дайчин юм.

Ташрамд дурдахад, сонс эргэлтийн төрлөөр геннисийн амжилтыг Армен улсын тамирчин Roman Sahradyan гэх тамирчин "1001" эргэлтээр эзэмшдэг байсан бол өнөөдөр ийнхүү Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагч 1111 эргэлтээр шинэчлэн тогтоож чадав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
26	16

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.148.00	3.153.0
EUR	3.305.0	3.320.0
CNY	472.00	474.00
RUB	53.50	54.80
JPY	23.10	23.40
KRW	2.42	2.45

ЗУРХАЙ



2022.07.01 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 2

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХӨХ БАР ӨДӨР

Үс засуулбал:

НАС АХАР БОЛНО

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 04.56-20.55

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал: Төмөр

Энэ өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнэс эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, бэрийн үйлд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одоодог баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 551,874,137

Эдгэрсэн

Нийт: 527,382,985

Нас барсан

Нийт: 6,356,428

Цахим шууданд

# ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ТӨГСӨЛТ БОЛЛОО



Монгол Улсын иргэн та Үндсэн хуулиар эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үүрэгтэй. Энэхүү үүргийг биелүүлэхэд иргэн танд хуулийн зохицуулалтаар хэд хэдэн боломжийг олгосон байдаг. Тодруулбал хугацаат цэргийн алба, оюутан цэрэгт хамрагдах, цэргийн дүйцүүлэх албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах, түүнчлэн цэргийн жинхэнэ албыг биеэр хаах гэх зэрэг багтдаг. Эдгээрийн нэг болох Цэргийн дүйцүүлэх албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнд цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн хэргийн бэлтгэл эзэмшүүлэх зорилготой дүйцүүлэх албаны бэлтгэл сургалт боллоо.

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах журамд шашин шүтлэг, ёс зүйн болон хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн жинхэнэ албыг биеэр хаах боломжгүй нь тогтоогдсон иргэд 24 сарын хугацаатай цэргийн дүйцүүлэх албыг хаах

боломжтой. Шаардлага, шалгуурыг давсан иргэдийг аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын гаргасан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөгөөр сургалтад заавал хамруулдаг. Цэргийн дүйцүүлэх албаны сургалт нь "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл", "Тусгай үүргийн бэлтгэл" сургалтуудаас бүрддэг юм. 2022 оны Нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газрын цэргийн штабуудын цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалт Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулагдаж дууслаа. Тус сургалт нь цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн томилгоот үүрэг гүйцэтгэхэд чиглэсэн мэдлэгийг олгодгоороо онцлог.

"Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалт" нь цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнд цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх,

цэргийн дүйцүүлэх алба хаах бэлтгэл эзэмшүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг гүйцэтгэх бэлтгэлийг хангахад чиглэгддэг. Энэ удаагийн сургалтаар батлан хамгаалахын эрх зүй, цэргийн дүрэм, зэвсэг техникийн бэлтгэл, биеийн тамирын бэлтгэл хичээлүүдийг онол, дадлагатай нь хослуулан явуулжээ. Сургалтад хамрагдсан дүйцүүлэх алба хаагчид Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 200 гаруй модыг тарьж дүүрэг орон нутагт бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ийнхүү нийслэл, дүүргийн цэргийн штабын төлөвлөгөөт сургалт болох цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалт амжилттай зохион явагдлаа. Эх орноо батлан хамгаалах үүрэгтнүүд ийнхүү бэлтгэгдэж байгаа нь улс орны туурга тусгаар орших ирээдүйн баталгаа билээ.



## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТҮРҮҮЧ, БАЙЛДАГЧ НАРЫН ДУНД УРАН ЗУРГИЙН УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын цэргийн гэрээт болон хугацаат цэргийн албаны түрүүч, байлдагч нарын дунд "Монгол Улсын төлөө зүтгэе" сэдэвт гар зургийн уралдааныг зарлалаа.

Уралдааны зорилго нь Зэвсэгт хүчинд алба хааж байгаа цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нарын авьяас чадварыг нээн илрүүлэх, ард иргэдэд Зэвсэгт хүчний үйл ажиллагааг уран сайхны аргаар дүрслэн үзүүлэх, эх орон, цэргийн албаар бахархах үзлийг түгээн дэлгэрүүлэхэд оршиж байгаа юм.

Түрүүч, байлдагч нар "Монгол Улсын төлөө зүтгэе" сэдвийн хүрээнд өөрийн уран сэтгэмж, төсөөллийн хүрээнд эх орон, Зэвсэгт хүчин, дайчин нөхдийнхөө онцлогийг илэрхийлсэн байх бөгөөд нэгтгэл, ангиас оролцох алба хаагч, уралдаанд ирэх



бүтээлийн тоо хязгааргүй юм.

Уралдаанд оролцогчид бүтээлээ 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдрүүдэд Хуурай замын цэргийн командлалын Цэргийн

сургалт, соёл хүмүүжлийн хэлтэст ирүүлэх ба шалгарсан уран уран зургийг 7 дугаар сарын 10-ны өдөр үзэсгэлэнгээр дэлгэнэ. Шалгарсан бүтээлийн эздийг мөнгөн урамшуулал болон бусад шагналаар шагнана.

## АЛДАР СПОРТ ХОРООНЫ ЧӨЛӨӨТ БӨХИЙН БАГ ТАМИРЧИД ТЭРГҮҮЛЭВ



Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн эрэгтэйчүүдийн 56, эмэгтэйчүүдийн 22 дахь удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 28-29-нд Сонгинохайрхан дүүргийн спорт хорооны зааланд боллоо.

Тус тэмцээнд Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны МУГТ хошууч Б.Одончимэг,

Г. М а н д а х н а р а н дасгалжуулагчтай чөлөөт бөхийн баг тамирчид оролцож, нийт 7 алт, 1 мөнгө, 5 хүрэл медаль хүртлээ. Эмэгтэй багийн дүнгээр МУГТ хошууч Б.Одончимэг дасгалжуулагчтай баг тамирчид тэргүүлж алтан медаль, эрэгтэй багийн дүнгээр МУГТ Г. М а н д а х н а р а н дасгалжуулагчтай баг

тамирчид дэд байрт шалгарч мөнгөн медаль хүртэв.

- Эрэгтэйчүүдийн:**
- 57кг-ийн жинд М.Даваабанди – хүрэл
  - 65кг-ийн жинд Ц.Цогбадрах – алт
  - 70 кг-ийн жинд Г.Бэгзжав – хүрэл
  - 74кг-ийн жинд О.Сүлдхүү – алт
  - 92 кг-ийн жинд Г.Ганхуяг - алт
  - 125кг-ийн жинд Э.Батмагнай – мөнгө

**Эмэгтэйчүүдийн:**

    - 50кг-ийн жинд Б.Мөнхнар – хүрэл
    - 53кг-ийн жинд Ч.Отгонтуяа – хүрэл
    - 55кг-ийн жинд Г.Отгонжаргал – алт
    - 55 кг-ийн жинд Б.Болор-Эрдэнэ – хүрэл
    - 62кг-ийн жинд С.Цэрэнчимэд – алт
    - 72кг-ийн жинд Э.Даваанасан – алт
    - 76кг-ийн жинд Г.Ариунжаргал – алтан медаль тус тус хүртлээ.